

## ЖАЙКА-гийн Монгол улс дахь сайн дурын үйл ажиллагааны товчоон

- 1991 оны 3 сар Японы далайн чанад дахь сайн дурын залуу гишүүн (JOCV)-ийг томилон ажиллуулах тухай хэлэлцээр байгуулагдав.
- 1992 оны 3 сар Японы далайн чанад дахь сайн дурын залуу гишүүдийн төлөөлөгчийн газар нээгдэж, анхны зохицуулагч ажилтан томилогдов.
- 1992 оны 4 сар Анхны 2 залуу сайн дурын гишүүн томилогдов.
- 1995 оны 2 сар Сайн дурын залуу гишүүн анх удаа орон нутагт томилогдов.
- 1997 оны 1 сар ЖАЙКА-гийн Монгол дахь Төлөөлөгчийн газар нээгдэв.
- 1997 оны 7 сар Сайн дурын ахмад гишүүн (Senior Volunteers)-ийг томилон ажиллуулах тухай хэлэлцээр байгуулагдав.
- 2000 оны 11 сар Анхны сайн дурын ахмад гишүүн 3 ажилтан томилогдов.
- 2003 оны 12 сар Техникийн хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулагдав.
- 2005 он Томилогдон ажилласан ЖАЙКА-гийн сайн дурын нийт гишүүдийн тоо 300 гарав.
- 2015 он Томилогдон ажилласан ЖАЙКА-гийн сайн дурын нийт гишүүдийн тоо 600 гарав.
- 2017 оны 3 сар Японы далайн чанад дахь сайн дурын залуу гишүүн (JOCV)-ийг томилон ажиллуулсаны 25 жилийн ой болно.

# Монгол дахь ЖАЙКА-гийн Сайн дурын гишүүд



### ЖАЙКА-гийн Монгол дахь Төлөөлөгчийн Газар

Бодь Цамхаг 7-р давхар, Сүхбаатарын талбай 3, Улаанбаатар (Төв шуудан 682, Улаанбаатар 211213, Монгол улс)  
Тел:+976-325939,311329 Факс:+976-310845 E-mail:mg\_oso\_rep@jica.go.jp  
<https://www.jica.go.jp/mongolia/office/index.html>

(2017 оны 2 сар)



Japan International Cooperation Agency

## ЖАЙКА-гийн сайн дурын гишүүн гэж хэн бэ ?

Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны байгууллага (JICA) нь Японы засгийн газрын хөгжлийн албан ёсны тусламж (ODA)-ийн үйл ажиллагааг нэгтгэн хэрэгжүүлэгч байгууллага бөгөөд хөгжиж буй орнуудын нийгэм эдийн засгийг хөгжүүлэх зорилгоор техник, буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлийн тусламж зэрэг төрөл бүрийн хамтын ажиллагааг хэрэгжүүлж байна.

Техникийн хамтын ажиллагааны хүрээнд Японы далайн чанад дахь сайн дурын залуу гишүүд (JOCV 20-39 насны) болон сайн дурын ахмад гишүүд (Senior Volunteers 40-69 насны)-ийг жил бүр дэлхийн 80 улсад нийтдээ 1500 орчим сайн дурын ажилтныг томилон ажиллуулж байна.

аТүүний дотор гол үүрэг гүйцэтгэж буй Японы далайн

чанад дахь сайн дурын залуу гишүүн (JOCV) нь харилцан ойлголцлыг гүнзгийрүүлэн та бүхний өөрсдийн хүчин чармайлтыг дэмжин ажиллах онцлогтой бөгөөд сайн дурын үйл ажиллагааны үндсэн суурь нь юм.

Далайн чанад дахь сайн дурын залуу гишүүд (JOCV) нь та бүхний тавьсан хүсэлтэд үндэслэн томилогддог. Монголын талын хүсэлтэд нийцсэн өөрийн ур чадвар, мэдлэг туршлагаа "Монголчуудын төлөө зориулъя" гэж хүссэн ажилтныг сонгон шалгаруулдаг. Томилогдохоосоо өмнө Японд 3 сарын сургалтад хамрагдсаны дараа та бүхний аймаг хот суманд томилогдон, та бүхэнтэй хамт амьдарч, та бүхний хэлээр ярьж, та бүхэнтэй хамт үйл ажиллагаа явуулна.



## ЖАЙКА-гийн Сайн дурын гишүүний мэргэжлийн салбар

<b>Япон хэл</b> (Япон хэлний боловсрол гэх мэт)	<b>Сургуулийн өмнөх боловсрол</b> (Цэцэрлэгийн багш гэх мэт)	<b>Боловсрол</b> (Бага сургуулийн боловсрол, биеийн тамир гэх мэт)
<b>Эрүүл мэнд</b> (Эх баригч, эрүүл ахуйч, сувилагч гэх мэт)	<b>Сэргээн засал</b> (Хөдөлгөөн засалч, Хөдөлмөр засалч гэх мэт)	<b>Тусгай хэрэгцээт боловсрол</b> (тусгай хэрэгцээт боловсролын багш, нийгмийн ажилтан гэх мэт)
<b>Спорт, оюун санааны өв тэгш боловсрол</b> (Сагсан бөмбөг, бадминтон, волейбол, жүдо гэх мэт)	<b>Аж үйлдвэрийн хөгжил</b> (Бизнесийн удирдлага, маркетинг гэх мэт)	
<b>Мэргэжлийн дадлага</b> (Компьютерийн зааварлагч багш, үсчин, хувцасны дизайн гэх мэт)	<b>Орон нутгийн хөгжил</b> (Нөхөрлөлийн хөгжил, сумын хөгжлийн зохион байгуулагч)	
<b>Байгаль орчин хамгаалал</b> (Байгаль орчны боловсрол, хог, хаягдлын менежмент, бохир ус)	<b>Дэд бүтэц, хот хөгжүүлэлт</b> (Барилга, зам гүүр, газар хэмжилт)	



ЖАЙКА-гийн сайн дурын ажилтнууд Монгол улсад томилогдохоос өмнө сургалтад хамрагддаг Нихонмацу дахь сургалтын төв

Монгол хэлний хичээл

Монгол хэлний сурах бичиг


## ЖАЙКА-гийн сайн дурын гишүүд Монгол улсад

1992 оны 4 сард далайн чанад дахь анхны сайн дурын залуу гишүүн 2 ажилтан, 2000 оны 11 сард анхны сайн дурын ахмад гишүүн 3 ажилтан Монгол улсад томилогдов. Түүнээс хойш 2016 оны эцсийн байдлаар нийт 643 ЖАЙКА-гийн сайн дурын ажилтан (JOCV-сайн дурын залуу гишүүн 502, SV-сайн дурын ахмад гишүүн 138, UNV 3) Монгол улсад томилогдон ажилласан байна.

Тэд нийслэл Улаанбаатар хотоос гадна 16 аймагт эрүүл мэнд, боловсрол, тусгай хэрэгцээт боловсрол, спорт зэрэг олон салбарт Монгол улсын хөгжлийн төлөө өөрсдийн мэдлэг чадвараа зориулан ажиллаж ирлээ. Мөн ЖАЙКА-гийн сайн дурын ажилтнууд Монгол улс дахь өдөр тутмын амьдрал үйл ажиллагаагаараа дамжуулан хоёр орны соёл, найрамдалт харилцааг гүнзгийрүүлэн хөгжүүлж байна.

**Японы сайн дурын ажилтнуудын Монгол улсад томилогдон ажилласан байдал** (Мэргэжлийн салбар тус бүрээр)

Төрөл зүйл оны	Япон хэл	Сургуулийн өмнөх шатнаас дээд боловсрол	Эрүүл мэнд	Сэргээн засал, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дэмжлэг	Спорт, оюун санааны өв тэгш боловсрол	Хөдөлмөр эрхлэлт, аж ахуйн нэгжийг дэмжих	Мэргэжлийн дадлага	Орон нутгийн хөгжил, байгаль орчин хамгаалал, дэд бүтэц, хот хөгжүүлэлт, бусад салбар	Тус бүрийн нийт тоо	Нийт
1991-1995	12	0	0	0	3	2	14	4	35	35
1996-2000	17	13	6	0	13	8	27	6	90	125
2001-2005	21	19	7	8	23	33	39	31	181	306
2006-2010	19	37	9	20	23	21	27	19	175	481
2011-2015	4	43	22	17	27	7	15	12	147	628
2016-	0	9	3	1	0	0	0	2	15	643
Нийт	73	121	47	46	89	71	122	74	643	



**Японы сайн дурын ажилтнуудын Монгол улсад томилогдон ажилласан байдал** (Аймаг тус бүрээр) (2016 оны 10 сарын байдлаар)

Улаанбаатар хот	Архангай	Говьсүмбэр	Төв	Баян-Өлгий	Булган	Орхон	Өвөрхангай	Завхан	Дорноговь	Хөвсгөл	Хөвд	Нийт
422	3	9	6	2	29	29	4	6	9	6	5	643



Хүүхэд хөхүүлэх талаар зөвлөгөө өгч буй Ёнэзава (Баруун гар талд)

## Эрүүл мэнд

(Эх баригч)

### Булган аймаг

Эрүүл мэндийн салбарт 2015 оныг дуустал 44 сайн дурын залуу гишүүн ажиллав. Тэдний дотроос Булган аймгийн Эрүүл мэндийн газар нь эх баригч зэрэг 5 ажилтанг хүлээн авсан бөгөөд жирэмсэн болон төрсөн эмэгтэйчүүд, Хөхүүл хүүхдийн амьдрах орчин нөхцлийг сайжруулах талаар хамтран ажиллаж ирлээ. Хэдий тийм боловч тус аймагт эрүүл мэндийн үйлчилгээ бүрэн хүрч чадахгүй байгаа газрууд олон байна. Монгол улсын хэмжээнд эх, хүүхдийн эрүүл мэндийн салбарт Японы сайн дурын залуу гишүүд цаашид ч их хувь нэмэр оруулах бүрэн боломжтой.

## Боловсрол

(Бага ангийн багш)

### Дархан-Уул аймаг

Боловсролын салбар нь сургуулийн өмнөх боловсролоос эхлэн бага дунд дээд боловсрол хүртэл өргөн хүрээтэй байдаг бөгөөд өнөөдрийг хүртэл Монгол улсад хамгийн олон сайн дурын залуу гишүүн томилогдон ажилласан салбаруудын нэг юм. Монгол улсад урьд нь хичээлийн агуулгыг сурагчдад цээжлүүлэх сургалтыг чухалчилдаг байсан бол сүүлийн үед сурагчдад бие даах болон сэтгэн бодох чадвар олгохоор боловсролын салбарын бодлогын өөрчлөлт явагдаж байна. Ийм цаг үед орон нутгийн боловсролын төвшний ялгааг багасгахад Японд багшилж байсан туршлагатай сайн дурын залуу гишүүн Монгол улсад их шаардлагатай байна.



Хичээлээ байнга сонирхолтой заахыг хичээдэг Комүра (Баруун гар талд)

## “Үргэлж эх, хүүхдийн дэргэд байхыг хүсдэг”

### Ёнэзава Юүка

Харъяа байгууллага: Булган аймгийн эрүүл мэндийн газар  
Томилолтын хугацаа: 2016/01/06 ~ 2018/01/05

Би Булган аймгийн эрүүл мэндийн газарт харьяалагдан, Булган аймгийн нэгдсэн эмнэлэг болон өрхийн эмнэлэгт ажиллаж байна. Эрүүл мэндийн газарт аймгийн нийт эх, хүүхдийн эрүүл мэндийн байдлын талаар судлахын зэрэгцээ дээрх 2 эмнэлэгт жирэмсэн эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн хяналт, төрөлт, хүүхэд хөхүүлэх, эх хүүхдийн хооллолтын орчин нөхцлийг сайжруулах талаар зөвлөгөө өгдөг. Миний эргэн тойрны хүмүүс надад их тусалдаг бөгөөд эхний үед тэдний ажлын хурд маш удаан байгаад их гайхсан. Японы ажлын бүх арга ажиллагаа Монголд таарахгүй учраас Монголын нөхцөлд таарсан ажлын үр ашигтай аргыг хайж олох нь чухал гэж бодож байна.

Би дунд сургуулийн сурагч байхаасаа эхлэн эрүүл мэндийн үйлчилгээнд бүрэн хамрагдаж чадахгүй байгаа жирэмсэн болон төрсөн эмэгтэйчүүд, тэдний хүүхдийн эрүүл мэндийг сайжруулах холбоотой ажил хийе гэж боддог байсан. Улмаар их сургуульд орж сувилахуй судлал, эх барих эмэгтэйчүүд судлалыг судласнаар эх баригчийн мэргэжилтэй болж эмнэлэгт мэргэжлээрээ ажиллах болсон. Энэ удаа Булган аймагт ажиллаж байгаа маань гадаадад ажиллаж байгаа анхны ажил юм.

Булган аймгийн зарим сумдад 200 километр алслагдсан газарт ганцхан эмнэлэгтэй сум ч байдаг. Ийм газрын эх, хүүхдийн эрүүл мэндийг сайжруулах ямар боломж байгаа, ямар аргаар хэрэгжүүлэх талаар холбогдох хүмүүстэй хамтран судалж эхлээд байна. Булган аймаг төдийгүй бусад аймагт ч гэсэн хэрэгжүүлэх үр дүнтэй аргыг олох талаар чармайж ажиллах болно.

## “Хичээл заахын зэрэгцээ би өөрөө суралцаж байна”

### Комүра Аяака

Харъяа байгууллага: Дархан-Уул аймгийн 1-р сургууль  
Томилолтын хугацаа: 2015/07/06 ~ 2017/03/20

Миний ажиллаж байгаа сургууль бол бага дунд ахлах сургуулийн боловсрол олгодог 12 жилийн сургалттай орон нутгийн сургууль болно. Би энэ сургуульд 1-5 ангид математик, зургийн хичээл заадаг. Монголын сургуулийн математикийн хичээлийн агуулга маш ихтэй тул сурагчдад хүндрэлтэй байдаг. Японы сургуультай харьцуулвал хичээлийн агуулгыг ойлгож чадалгүй хоцорсон сурагчдад тавих анхаарал бага зэрэг дутмаг юм шиг санагддаг. Тийм сурагчдыг багш нар дэмжиж, сургуулийн нийт сурагчдын математикийн мэдлэгийн төвшинг дээшлүүлэх аргын талаар бусад багш нартай хамтран эрэл хийж байна.

Би Японы Шизүока мужийн бага сургуулийн багш бөгөөд сургуулиасаа түр хугацааны чөлөө аван Монголд ирсэн. Хэд хоногийн өмнө миний багшилдаг Японы сургуулийн сурагчид Монгол сурагчидтай интернетээр холбогдон харилцсан. Хүүхдүүд өөрсдийн мөрөөдлийнхөө тухай зураг зурж түүнийгээ харилцан танилцуулсан бөгөөд хоёр орны хүүхдүүд олон шинэ зүйлийг сурч мэдсэн гэж бодож байна.

Би нэг удаа гадаадад ажиллаж үзье гэж бодон далайн чанад дахь сайн дурын залуу гишүүний өргөдөл өгсөн бөгөөд Монголд ирээд ажил дээрээ болон өдөр тутмын амьдрал дээр их зүйлүүдийг сурч мэдэж байна. Манай сургуулийн багш нар их элэгсэг нөхөрсөг хүмүүс. Монголд ирсэний дараа эхний үед би их ганцаардаж өөртөө итгэлгүй байсан. Японы сургуульд ч гэсэн гадаад орны хүүхдүүд олноороо ирж сурдаг болсон. Японд эргэж очоод тийм сурагчидтай урьдынхаас илүү ойр дотно харьцаж чадна гэж бодож байна.



Булган аймгийн эрүүл мэндийн газрын дарга

### С.Нарантуяа

Ёнэзава урьд өмнөх сайн дурын залуу гишүүний нэгэн адил маш нөхөрсөг, ажилдаа их хариуцлагатай ханддаг. Сайн эх баригч мэргэжилтэн бөгөөд эх барих, төрөлтийн талаар бидэнд их зүйлийг зааж өгдөг.

Нэгдсэн эмнэлэгт ажиллаж эхлээд дөнгөж 45 орчим хоноход тэр хугацаанд хийсэн ажиглалт дээрээ үндэслэн нярайн эндэгдлийг бууруулах арга болон шаардлагатай мэдлэгийг эх баригч нарт зааж сургах зэргээр ажлын олон амжилт гаргаад байна.



Булган аймгийн нэгдсэн эмнэлгийн төрөх тасгийн ахлах сувилагч

### Д.Энхтуяа

Ёнэзава тус эмнэлэгт ажиллаж эхлээд 3 сар болж байна. Энэ хугацаанд Монгол хэлийг хурдан сурч одоо Монголоор чөлөөтэй ярьдаг болсон. Ёнэзава сан-гаас жирэмсэн эмэгтэйчүүдийн сувилгаа, төрсний дараах асаргааны талаар олон чухал зүйлүүдийг сурч байна. Томилолтын 2 жилийн хугацаа нь маш богино байгаа бөгөөд наад зах нь 3 жил ажиллахыг хүсч байна.



Дархан-Уул аймгийн 1-р сургуулийн захирал

### С.Баттулга

Комүра багш зөвхөн сургалт төдийгүй хичээлээс гадуурх ажилд ч идэвхтэй оролцдог. Хэд хоногийн өмнө тэрээр аймгийн бага сургуулийн багш нарыг цуглуулж семинар зохион байгуулсан.

Гадаадын хичээлийн шинэ заах аргаас суралцсан нь их ач холбогдолтой болсон. Монгол улсын нутаг дэвсгэр өргөн уудам учраас орон нутагт бага дунд боловсрол бүрэн хүрч чаддаггүй. Ахлах сургуулийн элсэлтийн шалгалтын дүнгээс тэр байдал тодорхой харагддаг.

Орон нутгийн боловсролын төвшний ялгааг багасгахад Японы сайн дурын залуу гишүүд их хувь нэмэр оруулж чадна гэж бодож байна.



Бага ангийн сургалтын менежер

### Л. Булган

Би боловсролын салбарт 33 жил ажиллахдаа гадаадаас ирсэн багштай анх удаа хамт ажиллаж байгаа бөгөөд тэр нь Комүра багш юм. Комүра сан их хөгжилтэй зантай хүн учраас сурагчидтай ч гэсэн хурдан дотно болж чадсан. Хичээл заах арга болон жилийн хичээлийн хөтөлбөр боловсруулах талаар би болон бусад багш нар түүнээс шинэ санаа үргэлж авч байдаг. Мөн тэрээр Япон орны тухай олон зүйлийг зааж өгдөг. Монгол хэлийг хурдан сайн сурч байгаа тул математик, зургийн хичээлээс гадна өөр хичээл бас заалгаж гэж бодож байна.



Мацумото багш хүүхдэд хичээл зааж Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулна.(Зүүн гар талд)

# Тусгай хэрэгцээт боловсрол

## Улаанбаатар хот

Монгол улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн хэмжээ доогуур тэдний амьжиргааны төвшин сайн биш байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн оролцоог дэмжих талаар жирийн иргэдийн ойлголт дутмаг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол эзэмших боломж дутуу байгаа нь хөдөлмөр эрхлэлтийн хэмжээ доогуур байгаа шалтгаан болж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон тэдний гэр бүлийг дэмжих талаар Япон Монгол хоёр улс хамтран хийх зүйл маш их байна.

### Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулна

#### Мацумото Наоко

Харъяа байгууллага: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо  
Томилолтын хугацаа: 2016/03/28 ~ 2018/03/28

Миний ажиллаж буй ХБХЭЭХолбоо нь улсын хэмжээнд 18 салбартайгаар үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхчүүдэд зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, сургалтанд хамруулах, үйлчилгээнд холбон зуучлах, цаашлаад нөлөөлөл хийх зэрэг олон ажлуудыг хийдэг билээ. Тус холбоо Хүүхэд хөгжлийн 10 төвтэй бөгөөд 7 аймаг, Улаанбаатар хотод 3 байдаг. Би Улаанбаатар хотын Багваахай төвд ажилладаг. Энэ төв нь боловсрол, эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээг хүүхдэд хүргэдэг мэргэжилтнүүдээс бүрдсэн баг юм.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд наад зах нь өөрөө бие дааж шүдээ угааж, хувцсаа сольж чаддаг болбол тухайн хүүхэд бие даан амьдрахад их хувь нэмэр болох билээ. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувьд нийгэмд оролцох анхны алхам болох болно. Улмаар цаашид мэргэжил эзэмшин тодорхой орлоготой болж чадвал тухайн гэр бүлд болон улс нийгэмд хэрэгтэйгээс гадна тэр хүүхдэд өөрт нь юунаас ч илүү чухал юм. Хүүхдийн нийгэмд оролцох оролцоог нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулах нь миний ажлын зорилго юм.

Би Монголд ирээд хагас жил орчим болж байгаа бөгөөд Монгол хүмүүсийн анхаарлаа төвлөрүүлэх чадвар, хурдан шуурхай байдалд их гайхсан. Гэхдээ ажлыг урьдчилан төлөвлөж, төлөвлөгөөний дагуу нарийн гүйцэтгэхийн хувьд Япон хүн Монголчуудаас илүү гэж боддог. Харилцан сайн талаа зөв ашиглаж ажлын сайн үр дүн гаргая гэж бодож байна.



Хөгжлийн Бэрхшээлтэй Хүүхэдтэй Эцэг Эхийн Холбооны дэргэдэх Хүүхэд Хөгжүүлэх Багваахай Төвийн менежер, зөвлөх эмч

#### Н. Ууганцэцэг

Тус холбоо нь байгуулагдаад 16 жил болж байгаа ба бид 18 салбартайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Мацумото сан нь манай хүүхэд

хөгжлийн төвд ирж ажиллаж байгаа анхны сайн дурын залуу ажилтан юм. Мацумото сан нь манай багт нэн шаардлагатай байгаа сургуулийн өмнөх боловсролын багш бөгөөд тусгай хэрэгцээт боловсролын мэргэжилтэн тул хүүхдүүдийн сургалт хариуцахаас гадна багш хөгжил хариуцан тэдэнд сургалт явуулж байна. 2017 онд бид ХХТөвөө Багваахай хэмээн Мацумото сангийнхаа өгсөн нэрийг сонгон нэрлэх болсондоо баяртай байна.



Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбооны захирал

#### С. Сэлэнгэ

Манай Холбооны Багваахай төвийн багш нар Мацумото сантай хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх, тэдний тусгай хэрэгцээнд тулгуурлан багшийн заах арга зүйг сайжруулах тал дээр идэвхтэй ажиллаж байна. Төвд ирдэг хүүхдүүдийн хөгжлийн түвшин өөр өөр байдаг тул хүүхэд бүрт өөрсдийнх нь онцлог хэрэгцээнд тулгуурлан хөгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөх, хөгжилтэй, сонирхолтой байдлаар хичээлийг явуулах шаардлагатай байдаг. Мацумото сан нь бага насны хүүхдийг хөгжүүлэх тал дээр туршлагатай юм байна. Багш нар маань түүнтэй хамтран хичээлээ төлөвлөх, сонирхолтой байдлаар хөгжлийн үйл ажиллагааг явуулж, шаардлагатай үед хичээлийн хэрэгслийг өөрсдөө хийх гэх мэт олон зүйлийг түүнээс суралцаж байна.

# Спорт

(Жүдо)

## Хөвсгөл аймаг

Монгол улсад жүдо бөхийн олимпын анхны алтан медалийг авчирсан тамирчин Цагаанбаатарыг дээхэн үед Японы сайн дурын залуу гишүүн дасгалжуулж байсан. Өнгөрсөн 20 жилийн хугацаанд эрэгтэй эмэгтэй нийт 8 сайн дурын залуу гишүүн жүдогийн дасгалжуулагчаар томилогдон ажиллаж байгаа бөгөөд жүдогийн спортоор дамжуулан Японы ёс заншлыг Монголчуудад танилцуулж ирлээ. Өсвөр үеийн хүүхэд залуучуудын хүмүүжил, тамирчин бэлтгэхэд Монголын жүдо бөхийн байгууллагууд Японы сайн дурын залуу гишүүдийг цаашид үргэлжлүүлэн томилон ажиллуулахыг хүсч байгаа бөгөөд, ихээхэн итгэл найдвар тавьж байна.



Жүдогийн үндсэн мэхийг зааж буй Морита (Баруун гар талд)

### Жүдогийн арга мэх болон Японы ёс заншил -ыг зааж сургана

#### Морита Наоя

Харъяа байгууллага : Хөвсгөл аймгийн Аварга спорт сургууль  
Томилолтын хугацаа: 2014/10/06 ~ 2016/01/05

Би Мөрөн хотын спортын төрөлжсөн сургуульд үдээс өмнө 20, үдээс хойш 40 орчим сурагчдад жүдогийн хичээлийг 2 жил заасан. Сурагчид бүгдээрээ хүчтэй больё гэсэн их эрмэлзэлтэй байдаг бөгөөд тэр байдал нь бэлтгэлийн үед ч илт харягддаг. Би ч гэсэн тэр эрмэлзлэлийг нь дэмжиж янз бүрийн мэх, бэлтгэл хийх аргыг зааж сургасан бөгөөд өдөр тутмын бэлтгэл сургуулилтын үед хамгийн их анхаардаг зүйл бол жүдогийн үндсэн дасгал болон дэг жаяг юм. Миний зааж сургасан сурагчдын дотор жүдогийн тамирчин болохоор бэлтгэгдэж байгаа хэд хэдэн сурагчид байсан бөгөөд тэд ирээдүйд амжилт үзүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

Мөрөн хот өвөл их хүйтэрдэг боловч гадуур явахдаа хүйтний зориулалттай дулаан хувцас өмсөж дулаалвал тийм ч их хүйтэн биш, орон сууцны хувьд нийтийн халаалттай учир их дулаахан байсан. Хэдэн хүүхэд Япон хэл зааж өгөхийг их хүссэн тул зав гарсан үедээ тэр хүүхдүүдэд Япон хэл зааж өгсөн. Тэдний дотор Японы их сургуульд орсон хүүхэд ч байгаа. Мөрөн хотод өнгөрөөсөн 2 жил миний хувьд Япон Монголын харилцаанд өчүүхэн ч гэсэн хувь нэмэр оруулж чадсан, дурсамж ихтэй 2 жил болсон. Би бага сургуулийн 2-р ангиас их сургууль төгсөх хүртэл жүдоогоор тасралтгүй хичээллэсэн. Намайг өдий хүртэл өсгөж хүмүүжүүлсэн жүдо бөхийн ачийг хариулж бусдад зааж сургахыг хүсч сайн дурын залуу гишүүнээр томилогдон Монголд ирсэн боловч Монголд ирсэнээс хойш харин маш их зүйлийг би өөрөө заалгаж сурч мэдсэн. Монголд сурч мэдсэн зүйл миний цаашдын амьдралд ашиг тусаа өгнө гэдэгт итгэлтэй байна.

Монголын Жүдо бөхийн Холбооны гүйцэтгэх захирал

#### М.Бөхбат

Орон нутгаас авъяастнуудыг олж илрүүлэхийн тулд Монголын жүдо бөхийн холбоо улсын хэмжээнд жүдо бөхийг дэлгэрүүлэн хөгжүүлэхийг идэвхтэй зорьж байгаа. Зөвхөн телевизийн дэлгэцээр үзсэн Японы жүдо бөхийг орон нутгийн хүүхэд залуучууд бодитоор үзэх боломж олгож байгаа нь Японы сайн дурын залуу гишүүдийн оруулж буй их хувь нэмэр юм.

Монгол улсын хөдөө орон нутагт өвлийн улиралд сайн дурын залуу гишүүд ажиллаж амьдрах нь хүндрэлтэй байдгийг бид бүхэн сайн ойлгож байгаа.

Монголын жүдо бөхийн холбоо сайн дурын залуу гишүүдийн амьдралын нөхцөл байдлыг хангаж ажиллах бөгөөд цаашид ч гэсэн орон нутагт ажиллах сайн дурын залуу гишүүнийг хүлээн авах хүсэлтэй байна.



Монголын Жүдо бөхийн Академи

#### Г.Бат-Эрдэнэ

Монголын Жүдо академи хүүхдүүдэд ойлгомжтой жүдогийн дасгалын сурах бичгийг Монгол хэл дээр гаргахаар төлөвлөж байгаа. Жүдо бөхөд үндсэн дасгалууд, дэг жаяг их чухал байдаг. Японы сайн дурын залуу гишүүн тэдгээрийг гардан зааж байгаа тул

түүнтэй зэрэгцүүлэн хүүхдүүд өөрсдөө дасгалын сурах бичгийг уншсанаар жүдо бөхийн "хүндэтгэлээр эхэлж хүндэтгэлээр дуусдаг", "зөөлөн сэтгэл", "Япон сэтгэл зүй" зэргийг улам сайн ойлгодог болно. Улмаар Монголын хүүхэд залуучуудыг сурган хүмүүжүүлэхэд ч гэсэн их үр дүнтэй гэж бодож байна.